



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/266

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нутгийн захиргааны байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим программ нэвтрүүлэхэд Очир Ай Гүүгэл хязгаарлагдмал хариуцлагатай компанитай программ хангамж түрээслэх гэрээ байгуулж, тус ажлын зардалд нийт 5,000,000 (таван сая) төгрөг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг аймгийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, хамтран ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Т.Үржинпүрэв)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0544

D:My Doc. Zahiramj. Zasag darga